



САНГИЙН ЯАМ

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ БЭЛТГЭХ УДИРДАМЖ

*[Төсвийн удирдамж болон
төсөв бэлтгэх маягууд,
судалгааны хүснэгтүүд, MS
Word болон MS Excel файл
хэлбэрээр Сангийн яамны
веб хуудсанд тавигдсан
болно]*

[Холбоос линк](#)

АГУУЛГА

1.	ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ (ТЕЗ) НАРЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ХЯЗГААР	3
2.	ТЕЗ НАРЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ БЭЛТГЭХ ЗААВАР.....	3
2.1	Өмнөх жилийн удирдамжаас өөрчлөгдсөн зүйлс:	3
2.2	Төсвийн хязгаарт багтсан санал бэлтгэх	3
2.3	Төсвийн ангилал.....	3
2.4	Төсвийн маягт	4
2.5	Орон нутгийн төсвийн орлогын талаар	5
2.6	Орон нутгийн төсвийн зарлагын талаар	6
2.7	Төсвийн саналыг FISCAL-B программд оруулах	10
2.8	Төсвийн санал хүлээн авч хянах.....	10

1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ (ТЕЗ) НАРЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ХЯЗГААР

Улсын Их Хурлаас 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулиар 2026 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогыг ДНБ-ий 31.7 хувь, нийт зарлагыг ДНБ-ий 31.7 хувь байхаар тус тус тогтоосонтой нийцүүлж “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 оны төсвийн хязгаар”-ыг боловсрууллаа. *(Орон нутгийн төсвийн орлогын нийт хэмжээ болон зарлагын хязгаарын хэмжээг Сангийн сайдаас хүргүүлсэн албан бичгийн 2 дугаар хавсралтаас үзнэ үү)*

2. ТЕЗ НАРЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ БЭЛТГЭХ ЗААВАР

2.1 Өмнөх жилийн удирдамжаас өөрчлөгдсөн зүйлс:

- 2.1.1 Орон нутгийн төсвийн орлогын нийт хэмжээ болон зарлагын хязгаарыг тогтоож өгсөн;
- 2.1.2 Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүргийг төсвийн “хөтөлбөр”-ийн ангиллын зохицуулалт болон байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын тодорхой хэсгээр санхүүжүүлэх байгаль хамгаалах, нөхөн сэргээх “арга хэмжээний шинэчилсэн ангиллыг энэхүү удирдамжийн хавсралтаар хүргүүлсэн.
- 2.1.3 Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн мэдээллийг <https://bps.mof.gov.mn> холбоосоор нэвтэрч холбогдох маягтуудыг бүх аймаг, нийслэлийн ТЕЗ нар бөглөнө. Зааврыг энэхүү удирдамжийн хавсралтаар хүргүүлсэн.

2.2 Төсвийн хязгаарт багтсан санал бэлтгэх

- 2.2.1 2025 оны төсвийн жилээс эхлэн орон нутгийн төсвийн суурь зарлага ба нийт зарлагын хязгаарыг тогтоож байгаатай холбогдуулан зөвхөн зарлагын хязгаарт багтсан төсвийн санал хүлээн авна. Төсвийн хязгаараас хэтэрсэн саналыг Сангийн яам хянахгүй болохыг онцгой анхаарах.
- 2.2.2 Төсвийн төсөл хүлээн авах Fiscal программ дээр дээрх хөгжүүлэлтийг тусгасан бөгөөд систем дээр тэтгэвэрт гарах тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж, сонгуулийн үр дүнгээр албан тушаалаас чөлөөлөгдсөн албан хаагчид олгох тэтгэмжээс бусад зардлын нийт дүн хязгаар давсан тохиолдолд систем хадгалахгүй болохыг анхаарах.

2.3 Төсвийн ангилал

- 2.3.1 Төсвийн саналыг Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан ангиллын дагуу бэлтгэнэ.
- 2.3.2 Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т "эрхлэх асуудлын хүрээнд хөрөнгө оруулалтын арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийн хэмжээг холбогдох хөтөлбөрт тусгасан байх" гэж заасны дагуу орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын эх үүсвэрээр хэрэгжих төсөл арга хэмжээ бүрийг үндсэн чиг үүрэгт хамаарах төсвийн хөтөлбөрөөр урсгал болон хөрөнгийн зардлын төсвөө зохих хөтөлбөрт хуваарилах
- 2.3.3 Fiscal-д төсвийн санал оруулахдаа урсгал болон хөрөнгийн зардлыг үр дүн нь хамаарах хөтөлбөрийн ангиллыг Хүснэгт 1-д заасны дагуу зөв сонгож оруулах ба төсвийн зарлагын "Ангилалдаагүй бусад" ангиллыг сонгохгүй байх;

2.4 Төсвийн маягт ба заавар

- 2.4.1 Орон нутгийн төсвийн нийт орлого ба суурь орлогын орлогын тооцооллыг дэлгэрэнгүй байдлаар гаргаж ирүүлнэ.
- 2.4.2 Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн мэдээллийг бүх аймаг болон нийслэл Хавсралт №1-д заасны дагуу цахим системд боловсруулна
- 2.4.3 Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүргийг төсвийн "хөтөлбөр"-ийн ангиллын зохицуулалт болон байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын тодорхой хэсгээр санхүүжүүлэх байгаль хамгаалах, нөхөн сэргээх "арга хэмжээний шинэчилсэн ангиллыг энэхүү удирдамжийн Хавсралт №2-т заасны дагуу мөрдөнө

Хүснэгт 1. Төсвийн саналын маягт ба хавсралтууд

Маягт, хавсралтын нэр	Агуулга
1_Орон нутгийн 2026 оны төсвийн орлогын маягт	ОН-ын татварын болон татварын бус орлогын бодит хэмжээг тогтооход шаардлагатай мэдээллийн дэлгэрэнгүй асуулгыг татвар, төлбөр бүрээр тодорхойлох
2_Орон нутгийн 2026 оны төсвийн зарлагын маягт	Орон нутгийн суурь зарлагын тооцооллын санал бэлтгэх маягтууд
3_ Орон нутгийн 2026 оны төсвийн удирдамжийн Хавсралт №1	Орон нутгийн 2026 оны төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн мэдээллийг цахим системд боловсруулах зааварчилга
4_ Орон нутгийн 2026 оны төсвийн удирдамжийн Хавсралт №2	Орон нутгийн төсвийн төлөвлөлтөд ашиглах хөтөлбөрийн болон зориулалт-арга хэмжээний ангиллын хэрэглээнд мөрдөх зааварчилга
5_Fiscal-B гарын авлага	Fiscal B системийн гарын авлага

2.5 Орон нутгийн төсвийн орлогын талаар

Орон нутгийн 2026 оны төсвийн орлогын төслийг боловсруулахдаа орон нутгийн төсвийн суурь орлого, санхүүгийн дэмжлэг, дээд шатны төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг зохистой тогтоох үүднээс аймаг, нийслэлийн Засаг дарга дараах зарчмыг баримталж, шаардлага хангасан мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

- 2.5.1 Орон нутгийн орлогын төсөөлөл, гүйцэтгэл, холбогдох тайлбар танилцуулгыг орлогын эдийн засгийн ангиллын дагуу бэлтгэх;
- 2.5.2 Төсвийн орлогыг эдийн засгийн суурь үзүүлэлтийн таамаглалтай уялдуулж судалгаа тооцоонд үндэслэх;
- 2.5.3 Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.10 дахь заалтад заасны дагуу 2026 онд орон нутгийн төсөвт төвлөрөх аж ахуйн нэгжийн орлогын албан татварын төсөөлөл, судалгааг бэлтгэж ирүүлэх;
- 2.5.4 Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 345 дугаар тогтоолоор төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ил тод байдал, засаглалыг сайжруулах чиглэлийн хүрээнд орон нутгийн өмчит хуулийн этгээдийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн орлогыг тодорхойлох;
- 2.5.5 Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниудын үйл ажиллагааны талаарх мэдээлэл, үйлдвэрлэл борлуулалтын өмнөх онуудын гүйцэтгэл, ирэх оны төсөөллийн талаар мэдээлэл бэлтгэх;
- 2.5.6 Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу албан татвар ногдуулах жилийн орлогын төлөвлөгөөг боловсруулах. Үүнд:
 - 2.5.6.1 Нийгмийн даатгалын байгууллагаас НДШ ногдуулахаар тооцсон цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогын хэмжээг хувь хүний орлогын албан татвар ногдуулахаар тооцсон орлогын хэмжээтэй тулгаж, хөдөлмөр эрхлэгчдийн тоо, цалингийн сан зэрэг үзүүлэлтийн гүйцэтгэлийг 2025 оны хагас жилийн болон 2024 оны жилийн эцсийн байдлаар **1_ОН төсвийн орлогын тооцоолол** файл дахь **“5.XXOAT”** болон дагалдах хүснэгтүүдийг ашиглан цалингийн шатлал, интервалаар бэлтгэх;
 - 2.5.6.2 Иргэдийн хадгаламжийн хүүгийн орлогод ногдуулах албан татварын орлогыг тооцоход шаардагдах мэдээллийг холбогдох банк, санхүүгийн байгууллагуудаар гаргуулж, эдгээр мэдээлэлд үндэслэн хувь хүний орлогын албан татварын орлогын тооцооллыг бэлтгэх;
- 2.5.7 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, Галт зэвсгийн албан татварын

орлогын төлөвлөгөөг боловсруулахад холбогдох татварын алба, улсын бүртгэлийн байгууллага, цагдаагийн байгууллагаас шаардлагатай мэдээллийг гаргуулж, тус мэдээлэлд үндэслэн **1_ОН төсвийн орлогын тооцоолол** файл дахь “2. ҮХЭХ”, “3. Авто”, “8. Галт зэвсэг” болон тэдгээртэй дагалдах хүснэгтүүдийг ашиглан орлогын төлөвлөгөөг боловсруулах;

- 2.5.8 Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөг боловсруулахад холбогдох татварын алба, газрын албанаас шаардлагатай мэдээллийг гаргуулж, тус мэдээлэлд үндэслэн **1_ОН төсвийн орлогын тооцоолол** файл дахь “1. Газар” болон түүнтэй дагалдах хүснэгтүүдийг ашиглан орлогын төлөвлөгөөг боловсруулах;
- 2.5.9 Байгалийн нөөц ашигласны төлбөрийг Засгийн газрын 2022 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 2 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын хавсралтад заасан маягтуудыг холбогдох байгууллагын саналыг харгалзан бэлтгэж, тус мэдээлэлд үндэслэн байгалийн нөөц тус бүрээр тооцоолсон орлогын төлөвлөгөөг ирүүлэх;
- 2.5.10 Хог хаягдлын тухай хууль болон Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 192, А/243 дугаар тушаалаар хамтран баталсан “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тооцох аргачлал”-ын дагуу нэгдсэн журмаар тооцож ирүүлэх;
- 2.5.11 Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар тогтоосон албан татварын хувь, хэмжээний мэдээллийг холбогдох тогтоол, шийдвэрийн хамт хавсаргаж ирүүлэх;
- 2.5.12 Шинээр батлагдсан хууль тогтоомж, төсвийн орлого бүрдүүлэлтэд нөлөө үзүүлэх үр дагавар бүхий шийдвэрийн нөлөөллийг тооцож, холбогдох мэдээлэл материалыг хавсаргаж ирүүлэх (Иргэдийн хурлын тогтоол г.м);
- 2.5.13 Орон нутгийн төсвийн орлогын тооцооллыг энэхүү удирдамжид хавсаргасан **1_ОН төсвийн орлогын тооцоолол** дагуу бэлтгэж, шаардлагатай мэдээллийг баталгаажуулан ирүүлэх бөгөөд ийнхүү ирүүлээгүй тохиолдолд орлогын төсөөллийг Сангийн яаманд байгаа мэдээлэлд үндэслэн боловсруулах болно гэдгийг анхаарна уу.

2.6 Орон нутгийн төсвийн зарлагын талаар

Төрийн албан хаагчдын орон тооны талаар

- 2.5.14 Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяанд хамаарах төсвийн байгууллагуудын цалин хөлсний зардлыг тооцохдоо Засгийн газраас баталсан төрийн захиргаа, төрийн үйлчилгээний ангилал, зэрэглэл, түүнд харгалзах албан тушаалын жагсаалтаар ажилчдын тоог гаргаж, Засгийн газраас баталсан тухайн албан тушаалын цалингийн хэмжээгээр бүтэн жилээр тооцох;

2.5.15 “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгаж оновчтой болгох, төрийн үйлчилгээний цахимжилтыг эрчимжүүлэх, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-нд туссан багш, эмч нараас бусад төрийн албан хаагчийг орон тоог 9 хувиар бууруулах арга хэмжээг 2025 оны тодотголын хүрээнд эхлүүлэхээр тооцож төсвийн төсөлд тусган УИХ-д өргөн мэдүүлээд байна. Тус арга хэмжээ нь 2026 онд үргэлжлүүлэхээр төлөвлөж байгаа тул дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх:

2.5.15.1 чиг үүргийн давхардалтай эсхүл нэг төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн харьяанд байгаа чиг үүрэг ойролцоо, харилцан уялдаа бүхий үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа төсөвт байгууллагуудыг нэгтгэх;

2.5.15.2 төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах үүрэгтэй харуул хамгаалалт, халаалт дулаан, цэвэрлэгээ зэрэг нийтлэг ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх;

2.5.15.3 2025, 2026 оны төсвийн жилд өндөр насны тэтгэвэр тогтоолгох болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн мөн сул орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх, шинээр ажлын чиг үүрэг, албан тушаалын орон тоо бий болгохгүй байх, ажлын байрны ачааллыг нягтруулах зэргээр цалин хөлсний зардлыг хэмнэх.

2.5.15.4 байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын тодорхой хэсгээр санхүүжүүлэх байгаль хамгаалах, нөхөн сэргээх “арга хэмжээг энэхүү удирдамжийн хавсралтаар хүргүүлсэн шинэчилсэн ангиллын дагуу төсвийн төлөвлөлтийн FISCAL програмд оруулах ба “817010 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх” арга хэмжээг орон нутгийн төсөвлөлтөд 2026 оноос эхлэн ашиглахгүй. Тиймээс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний саналыг зөвхөн шинэчилсэн ангиллын дагуу хянана.

Төсвийн хэмнэлтийн талаар

2.5.16 Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан мөн 2025 оны төсвийн тодотголын төсөлд туссан дараах арга хэмжээг 2026 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа тул дараах зардлыг төсөвт тусгахгүй. Үүнд:

2.5.16.1 төсвийн хөрөнгөөр цаасан мэндчилгээ илгээх, бэлэг дурсгалын зүйлс, цүнх, календарь зэрэг зүйлс бэлтгэх, худалдан авахтай холбоотой зардал;

2.5.16.2 төсвийн хөрөнгөөр компьютер, хэвлэгч, хувилагч, тавилга, техник хэрэгсэл, автомашин шинээр худалдан авах зардал;

2.5.16.3 төрийн өндөр албан тушаалтны албан ёсны гадаад томилолт, Засгийн газраас зөвшөөрсөн тохиолдолд Засгийн газрын гишүүдийн гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авахаас бусад гадаад томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах зардал;

2.5.16.4 үндэсний аюулгүй байдал, онцгой байдал, цагдаа, шүүхийн шинжилгээ, хил хамгаалах, хилийн шалган нэвтрүүлэх, батлан хамгаалах салбарын анги, нэгтгэлүүд, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, эрүүл мэнд, боловсролын салбараас бусад салбар төсвийн хөрөнгөөр сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зохион байгуулахгүй байх, түүнтэй холбоотой зардал;

2.5.16.5 төсвийн хөрөнгөөр нийтээр тэмдэглэх баяр ёслол, салбарын өдөр, нэрэмжит болон тэмдэглэлт ой, аялал зугаалга, тойрон аялал, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах зардал;

Бусад арга хэмжээний талаар

- 2.5.17 Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяанд хамаарах сангуудын төлөвлөлт, хэрэгжилтийг “Төсвийн тухай хууль” болон “Засгийн газрын тусгай сангийн тухай хууль”-д тус тус нийцүүлэн төлөвлөж хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах. Тухайлбал, “Байгаль хамгаалах сан”, “Эрсдэлээс хамгаалах сан” зэрэг тодорхой хуулийн зохицуулалтгүй сангуудыг тусдаа дансанд төсөвлөхгүй байх.
- 2.5.18 Аймаг/нийслэлийн болон сум/дүүргийн ИТХ-ын тогтоолын 1 дүгээр хавсралтаар зөвхөн аймгийн эсвэл сумын төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг батлах /сумын төсвийн суурь зарлага, суманд олгож байгаа орлогын шилжүүлэг санхүүгийн дэмжлэгийг оруулахгүй байх/;
- 2.5.19 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-т заасан хувь, хэмжээний доод хязгаараас багагүй байхаар тооцож ирүүлэх. Ингэхдээ удирдамжийн Хавсралт №2-т заасан арга хэмжээний ангиллын зохицуулалтыг дагаж мөрдөх;
- 2.5.20 Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 38 дугаар зүйлийн Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэгт “38.1.2. Хүүхэд хамгааллын санхүүжилт, хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажил, үйлчилгээний зардлыг орон нутгийн төсөвт жил бүр тусгаж батлах”, 39 дүгээр зүйлийн Бүх шатны засаг даргын чиг үүрэгт “39.1.2. Тухайн шатны жилийн төсвийн төсөлд хүүхэд хамгааллын санхүүжилтийг тусгах” чиг үүрэгтэй гэж заасны дагуу орон нутгийн төсвөөс “Хүүхдийн хөгжил, хамгаалал”-ын үйл ажиллагаанд зориулсан зардал төлөвлөх.

Ингэхдээ удирдамжийн Хавсралт №2-т заасан арга хэмжээний ангиллын зохицуулалтыг дагаж мөрдөх;

- 2.5.21 2026 оны орон нутгийн суурь зарлагад эрүүл мэнд, боловсрол, нийгэм, соёлын байгууллагуудын барилгын ашиглалтын тогтмол зардал болон урсгал засварын зардлын тооцооллыг хавсралт дахь [НМ-12а](#) маягтад гэрэл, цахилгааны, [НМ-12б](#) маягтад цэвэр, бохир усны, [НМ-12в](#) маягтад халаалтын, [НМ-12г](#) маягтад байрны түрээсийн, [НМ-12д](#) маягтад урсгал засварын зардлыг байгууллага тус бүрээр тооцоолж, холбогдох нотолгоог хавсаргах ба нэгтгэлийг [НМ-12](#) маягтад оруулна.
- 2.5.22 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж болон бараа үйлчилгээний бусад зардал эдийн засгийн ангилал дээрх цалин хөлс, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах зардал зэрэг бусад эдийн засгийн ангилалд тусгах боломжтой зардлыг холбогдох эдийн засгийн ангилалд тусгах. Дээрх эдийн засгийн ангилалд тусгах зардлын задаргааг Хавсралт 11а, 11б-д тусгах. Хэрэв өөр эдийн засгийн ангилалд тусгах боломжтой зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж болон бараа үйлчилгээний бусад зардал эдийн засгийн ангилалд төлөвлөн ирүүлсэн тохиолдолд төсөвт тусгахгүй.
- 2.5.23 Кибер аюулгүй байдлыг хангах зориулалтыг 80801 үндсэн үйл ажиллагааны мэдээлэл технологийн зардлаас 803170 Кибер аюулгүй байдлыг хангах зориулалтын ангилалд салган төлөвлөнө. Уг зардалд кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэх төлбөр, мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлийн стандарт нэвтрүүлэх төлбөр, мэдээллийн аюулгүй байдлын хяналт, удирдлага, хамгаалалтын тоног төхөөрөмж, лицензийн төлбөр, хамгаалалтын программ хангамжийн лицензийн төлбөртэй холбоотой зардлууд багтана.
- 2.5.24 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасан Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын гүйцэтгэлийн дэлгэрэнгүй тайланг 2024 он, 2025 оны эхний хагас жилийн байдлаар гарган ирүүлэх
- 2.5.25 Цэргийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.8-д Цэргийн дүйцүүлэх албыг орлуулан хаасан мөнгөн төлбөрийн 50 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, батлан хамгаалах ажиллагаанд зарцуулахаар заасантай холбогдуулан гүйцэтгэлийн дэлгэрэнгүй тайланг 2024 он, 2025 оны эхний хагас жилийн байдлаар гарган ирүүлэх
- 2.5.26 Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, хэрэгжүүлсэн ажлын тайланг мөн 2024 он, 2025 оны эхний хагас жилийн байдлаар гарган ирүүлэх

2.7 Төсвийн саналыг FISCAL-B программд оруулах

Төсвийн төлөвлөлтийн үйл явцыг Fiscal программаар дамжуулан авах ба 2025 оны төсвийн орлого болон зарлагын саналыг FISCAL-B хувилбарыг ашиглаж Сангийн яаманд ирүүлнэ. Системд өгөгдөл оруулах зааварчилгааг энэхүү удирдамжид хавсаргасан **3_Fiscal-B гарын авлага** файлаас харна уу. Программд өгөгдөл оруулахтай холбоотой тодруулгыг Сангийн яамны ТБТГ-ын зөвлөх Ш.Оюунбаатар oyunbaatar@mof.gov.mn хаягаар болон **51-265753** утсаар лавлана уу.

2.8 Төсвийн санал хүлээн авч хянах

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн саналыг дор дурдсан хугацаанд хянаж Засгийн газар болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхэд бэлтгэнэ.

Хүснэгт 2. Төсвийн төсөл бэлтгэх процесс

Хяналт болон төлөвлөлтийн процесс	Эхлэх болон дуусах хугацаа
Аймаг, нийслэлийн 2026 оны төсвийн суурь орлого, суурь зарлагын саналыг хянах	VII/28- VIII/01
Жилийн төсвийн төсөлд инфляцын болон бусад бодлогын тохируулга хийх	VIII/01- VIII/10
Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн төсөл, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн төслийг тус тус холбогдох бусад материалын хамт Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхэд бэлтгэх	VIII/11- VIII/15
ТЕЗ нартай 2026 оны төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг хийж холбогдох тохируулгыг хийн, УИХ-д өргөн мэдүүлэхэд бэлтгэх	VIII/15- VIII/30

Төсвийн Ерөнхийлөн захирагчид төсвийн төслийн саналаа бэлтгэхдээ маягтад заасан үзүүлэлтийг бүрэн бөглөж, мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг Төсвийн тухай хуульд заасны дагуу хариуцах бөгөөд дээрх шаардлагуудыг хангахгүй, холбогдох материалууд дутуу төсөл, арга хэмжээг хүлээн авахгүй, албан бичгээр буцаахыг анхаарна уу.

Аймаг, нийслэлийн төсвийн саналыг дараах хуваарийн дагуу хянаж эцэслэнэ.

Хүснэгт 3. Аймаг нийслэлийн төсвийн санал хянуулах хуваарь

Төсвийн санал хүлээн авч хянах хугацаа		Аймаг/Нийслэл
2025.07.28	Даваа	Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай
2025.07.29	Мягмар	Говь-Сүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дорнод
2025.07.30	Лхагва	Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай
2025.07.31	Пүрэв	Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс
2025.08.01	Баасан	Ховд, Хөвсгөл, Хэнтий, Улаанбаатар.

--o0o--